4417 44353  
ЕЮА0056 9025707

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт  | Төсвийн төлөвлөгөө    | Төсвийн гүйцэтгэл     | Гүйцэтгэл зөрүү       |
|--------|---|-----------------------|-----------------------|-----------------------|
| II     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                        | <b>752,176,600.00</b> | <b>745,750,123.08</b> | <b>6,426,476.92</b>   |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>752,176,600.00</b> | <b>745,750,123.08</b> | <b>6,426,476.92</b>   |
| 210    | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                          | <b>749,414,600.00</b> | <b>742,989,770.08</b> | <b>6,424,829.92</b>   |
| 2101   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                        | <b>486,815,300.00</b> | <b>486,314,333.88</b> | <b>500,966.12</b>     |
| 210101 | Үндсэн цалин  | 239,560,000.00        | 241,950,822.43        | (2,390,822.43)        |
| 210102 | Нэмэгдэл  | 136,222,300.00        | 143,678,127.51        | (7,455,827.51)        |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт   | 65,100,000.00         | 63,196,990.47         | 1,903,009.53          |
| 210104 | Урамшуулал  | 29,133,000.00         | 24,270,753.76         | 4,862,246.24          |
| 210105 | Гэрээт ажлын хөлс   | 16,800,000.00         | 13,217,639.71         | 3,582,360.29          |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>           | <b>61,893,100.00</b>  | <b>54,512,109.71</b>  | <b>7,380,990.29</b>   |
| 210201 | Тэтгэврийн даатгал  | 42,000,000.00         | 37,032,309.71         | 4,967,690.29          |
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 5,030,800.00          | 4,427,400.00          | 603,400.00            |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 4,024,500.00          | 3,542,000.00          | 482,500.00            |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал  | 776,300.00            | 655,400.00            | 120,900.00            |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал   | 10,061,500.00         | 8,855,000.00          | 1,206,500.00          |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | <b>69,896,700.00</b>  | <b>68,916,375.49</b>  | <b>980,324.51</b>     |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 14,943,300.00         | 14,646,465.47         | 296,834.53            |
| 210302 | Түлш, халаалт   | 51,920,700.00         | 51,833,521.02         | 87,178.98             |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 3,032,700.00          | 2,436,389.00          | 596,311.00            |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>39,041,400.00</b>  | <b>38,841,760.00</b>  | <b>199,640.00</b>     |
| 210401 | Бичиг хэрэг   | 5,477,400.00          | 5,474,200.00          | 3,200.00              |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 28,399,900.00         | 28,399,140.00         | 760.00                |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                              | 3,124,100.00          | 2,928,670.00          | 195,430.00            |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал       | 240,000.00            | 240,000.00            | -                     |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                     | 1,800,000.00          | 1,799,750.00          | 250.00                |
| 2105   | <b>Норматив зардал</b>  | <b>600,000.00</b>     | <b>600,000.00</b>     | <b>-</b>              |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                     | 600,000.00            | 600,000.00            | -                     |
| 2106   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>25,736,400.00</b>  | <b>25,735,720.00</b>  | <b>680.00</b>         |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл   | 8,736,400.00          | 8,735,900.00          | 500.00                |
| 210604 | Урсгал засвар   | 17,000,000.00         | 16,999,820.00         | 180.00                |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>                                   | <b>6,668,700.00</b>   | <b>5,971,400.00</b>   | <b>697,300.00</b>     |
| 210702 | Дотоод албан томилолт   | 6,668,700.00          | 5,971,400.00          | 697,300.00            |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>50,463,000.00</b>  | <b>53,838,905.00</b>  | <b>(3,375,905.00)</b> |

|             |  |                       |                       |                     |
|-------------|--|-----------------------|-----------------------|---------------------|
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 48,714,000.00         | 52,208,750.00         | (3,494,750.00)      |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 330,000.00            | 310,000.00            | 20,000.00           |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 636,500.00            | 636,475.00            | 25.00               |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 356,500.00            | 356,500.00            | -                   |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 226,000.00            | 218,000.00            | 8,000.00            |
| 210807      | Газрын төлбөр  | 200,000.00            | 109,180.00            | 90,820.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>8,300,000.00</b>   | <b>8,259,166.00</b>   | <b>40,834.00</b>    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 5,500,000.00          | 5,459,666.00          | 40,334.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,800,000.00          | 2,799,500.00          | 500.00              |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>2,762,000.00</b>   | <b>2,760,353.00</b>   | <b>1,647.00</b>     |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>2,762,000.00</b>   | <b>2,760,353.00</b>   | <b>1,647.00</b>     |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 2,762,000.00          | 2,760,353.00          | 1,647.00            |
| <b>III</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>752,176,600.00</b> | <b>742,250,123.08</b> | <b>9,926,476.92</b> |
| <b>32</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>751,176,600.00</b> | <b>742,250,123.08</b> | <b>9,926,476.92</b> |
| 320001      | Орон нутгийн төсвөөс   | 751,176,600.00        | 742,250,123.08        | 9,926,476.92        |
| <b>35</b>   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | <b>1,000,000.00</b>   |                       | <b>1,000,000.00</b> |
| 350002      | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 1,000,000.00          | -                     | 1,000,000.00        |
| 4           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     | -                     | 4,493,980.00          | (4,493,980.00)      |
| 5           | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    | -                     | 11,493,980.00         | (11,493,980.00)     |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>  | <b>1.00</b>           | <b>1.00</b>           | <b>-</b>            |
| 610001      | Төсвийн байгууллага  | 1.00                  | 1.00                  | -                   |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>   | <b>29.00</b>          | <b>29.00</b>          | <b>-</b>            |
| 620001      | Удирдах ажилтан  | 8.00                  | 8.00                  | -                   |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан  | 10.00                 | 10.00                 | -                   |
| 620003      | Үйлчлэх ажилтан  | 8.00                  | 8.00                  | -                   |
| 620004      | Гэрээт ажилтан   | 3.00                  | 3.00                  | -                   |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>   | <b>29.00</b>          | <b>29.00</b>          | <b>-</b>            |
| 650001      | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                                   | 9.00                  | 9.00                  | -                   |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                           | 10.00                 | 10.00                 | -                   |
| 650010      | Гэрээт ажилтан   | 3.00                  | 3.00                  | -                   |
| 650011      | Улс төрийн албан хаагч (УТ)  | 7.00                  | 7.00                  | -                   |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код    | Үзүүлэлт   | Төсвийн төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү /төгрөгөөр/ |
|--------|--|--------------------|-------------------|-----------------------------|
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | -                  | 299,040,865.00    | (299,040,865.00)            |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ  | -                  | 299,040,865.00    | (299,040,865.00)            |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | -                  | 295,271,266.00    | (295,271,266.00)            |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж   | -                  | 35,090,519.00     | (35,090,519.00)             |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | -                  | 35,090,519.00     | (35,090,519.00)             |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал  | -                  | 260,180,747.00    | (260,180,747.00)            |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал  | -                  | 260,180,747.00    | (260,180,747.00)            |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | -                  | 3,769,599.00      | (3,769,599.00)              |
| 2133   | Олгосон санхүүжилт, шилжүүлэг  | -                  | 3,769,599.00      | (3,769,599.00)              |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг          | -                  | 3,769,599.00      | (3,769,599.00)              |
| I      | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   | -                  | 299,040,865.00    | (299,040,865.00)            |
| 1311   | Нэмэлт санхүүжилтийн орлого  | -                  | 299,040,865.00    | (299,040,865.00)            |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | -                  | 19,000,000.00     | (19,000,000.00)             |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | -                  | 195,979,000.00    | (195,979,000.00)            |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | -                  | 84,061,865.00     | (84,061,865.00)             |

2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт                               | Төлөвлөгөө | Гүйцэтгэл     | Зөрүү дүн /төгрөгөөр/ |
|-----|--|------------|---------------|-----------------------|
| I   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | -          | 10,500,000.00 | (10,500,000.00)       |
| 12  | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                    | -          | 10,500,000.00 | (10,500,000.00)       |
| 120 | Нийтлэг татварын бус орлого            | -          | 10,500,000.00 | (10,500,000.00)       |

|        |   |   |               |                 |
|--------|---|---|---------------|-----------------|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого                    | - | 10,500,000.00 | (10,500,000.00) |
| II     | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                   | - | 3,500,000.00  | (3,500,000.00)  |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                       | - | 3,500,000.00  | (3,500,000.00)  |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                    | - | 3,500,000.00  | (3,500,000.00)  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                              | - | 3,500,000.00  | (3,500,000.00)  |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | - | 3,500,000.00  | (3,500,000.00)  |
| III    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | - | 7,000,000.00  | (7,000,000.00)  |
| VIII   | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)   | - | 7,000,000.00  | (7,000,000.00)  |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл    | - | 4,493,980.00  | (4,493,980.00)  |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | - | 11,493,980.00 | (11,493,980.00) |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм, төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

Засаг даргын дэргэдэх тасаг, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээнэ. Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Тайлант онд хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг иргэдийн нийтлэг эрх ашигт тулгуурлан шийдвэрлэж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, гүйцэтгэсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль Захиргааны ерөнхий хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 60,670.1 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 57,457.8 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

### **5.1. Залруулсан алдаа**

1. Аж ахуйн нэгжээс нийгмийн хариуцлагын олгосон 19.0 сая төгрөгийн дэмжлэгийг орлогын ангиллын буруу илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил, гүйлгээг гарахаас нь хянан, баталгаажуулах”*, Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 338 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 2 дугаар зүйлийн 2.9-т *“төсвийн захирагчдаас дараагийн шатны төсвийн эрх захирагчдад олгох татаас, санхүүжилтийн дансанд зориулалтаар нь ангилж бүртгэнэ”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Тайлант оны цалингийн зардлыг даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 300.4 мянган төгрөгөөр, татварын суутгалыг 225.6 мянган төгрөгөөр, цалингийн урьдчилгааг 56,550.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. Энэ нь Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 338 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсгийн *“хүлээн зөвшөөрөх болон үнэлэх шалгуур нөхцөлийг хангасан тайлант хугацаанд хамаарах бараа үйлчилгээний зардлыг дэд ангиллаар бүртгэнэ”* гэж заасныг зөрчсөн байна.

3. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого болох төлөгдөөгүй түрээсийн орлогын 2,581.8 мянган төгрөгийг авлагад бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *“үнэн зөв байх”*, 8 дугаар зүйлийн 8.4-т *“аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”*, 20 дугаар зүйлийн 20.2.5-т *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил, гүйлгээг гарахаас нь хянан, баталгаажуулах”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 5,794.0 мянган төгрөгийн 5 зөрчил илэрсэнд 5,794.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 9,000.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,794.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### **5.2. Төлбөрийн акт**

Аудитаар тогтоосон төлбөрийн акт байхгүй болно.

### **5.3. Албан шаардлага**

1. Төрийн албан хаагчдын орон сууцын түрээсийн төлбөрийн болон бусад тооцооны 2,622.9 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

2. Тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэхдээ ажил олгогчоос шилжүүлэх 2,743.0 мянган төгрөгийг үндсэн цалингаас, шатахууны үнэ 428.3 мянган төгрөгийг түлш халаалтын зардлаас шилжүүлсэн нийт 3,171.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

#### **5.4. Зөвлөмж**

1. Тайлант онд 35,732.0 мянган төгрөгийн 3 орлогын гүйлгээ, 59,458.0 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн 107,040.5 мянган төгрөгийн 17 орлогын гүйлгээ, 97,286.1 мянган төгрөгийн 14 зарлагын гүйлгээг хуулийн хугацаанд нь байршуулаагүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх, мэдээллийн ил тод байдал алдагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т “цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт”, 8.4.8-т “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны системд мэдээлээгүй 6 мэдээллийг нөхөн байршуулах, цаашид хуулийг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

2. Ашиглах жил оруулаагүйгээс элэгдэл тооцоолоогүй, мөн ашиглах жил дуусаж байгаа үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, үндсэн хөрөнгийг шийдвэрлэх боломжгүй эрсдэл үүсэх магадлалтай. Энэ нь Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 338 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.35 дахь хэсгийн “элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн

*элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэж заасныг зөрчсөн байна.*

**Өгсөн зөвлөмж:** Ашиглах жил дуусаж байгаа хуримтлагдсан элэгдэлгүй хөрөнгийг журмын дагуу шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3. Аж ахуйн нэгжийн хандив болон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос худалдан авсан үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-т *“төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчит бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч, хуулийг хэрэгжилтийг хангах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган  
төгрөгөөр  
/

| Алдааны товч утга   | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                | Буруу тусган илэрхийлсэн |               | Үүнээс     |                 |              |     | Зөвлөмж |     |
|---|------------|-----------------|-----------------------------------|----------------|--------------------------|---------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
|   | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн            | Тоо                      | Дүн           | Залруулсан |                 | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|   |            |                 |                                   |                |                          |               | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн |         |     |
| Аж ахуйн нэгжээс олгосон дэмжлэгийг орлогын ангилал буруу илэрхийлсэн | 1          | 19,000.0        |                                   |                | 1                        | 19,000.0      | 1          | 19,000.0        |              |     |         |     |
| Цалингийн зардлыг буруу илэрхийлсэн                                   | 1          | 35,876.0        |                                   |                | 1                        | 35,876.0      | 1          | 35,876.0        |              |     |         |     |
| Үндсэн үйл ажиллагааны орлогыг авлагад бүртгээгүй байна               | 1          | 2,581.8         | 1                                 | 2,581.8        |                          |               | 1          | 2,581.8         |              |     |         |     |
| <b>Дүн</b>  | <b>3</b>   | <b>57,457.8</b> | <b>1</b>                          | <b>2,581.8</b> | <b>2</b>                 | <b>54,876</b> | <b>3</b>   | <b>57,457.8</b> |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган  
төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс        |                 |         |                                      |   |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|--------------------------------------|---|
|                    |             | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |
|                    |             |               |                 |         |                                      |   |

